



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 2186

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм,  
зохион байгуулалтын бүтцийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай” 50 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 376 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрмийг 1 дүгээр, зохион байгуулалтын бүтцийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан дүрэм, зохион байгуулалтын бүтцийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” А/21 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” А/70 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД

Т.МӨНХСАЙХАН



Эрүүл мэндийн сайдын  
2021 оны 10 сарын 10-ны өдрийн Ятушаалын  
нэгдүгээр хавсралт 16

51

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Төв" гэх/ нь эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, стандарт, удирдамжийг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, шийдвэр гаргагчдыг нотолгоо, статистик тоо мэдээллээр хангах, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэл, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаа болон амбулаторын үзлэгийн цаг товлох үйлчилгээг үндэсний хэмжээнд зохицуулж холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага мөн.
- 1.2. Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Донорын тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль, тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хурээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.
- 1.3. Байгууллагын оноосон бүтэн нэр нь "Эрүүл мэндийн хөгжлийн төв", оршин байгаа газар нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны гудамж – 13Б
- 1.4. Төвийн нэрийг англи хэл дээр "Center for Health Development" гэнэ.
- 1.5. Энэхүү дүрмийн зорилго нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоон хяналт тавих, эд хөрөнгийн эрх, түүнээс үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино. Энэхүү дүрэм нь төвийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.
- 1.6. Төв нь өөрийн бэлгэдэл /эмблем/-тэй байх бөгөөд тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.
- 1.7. Энэхүү дүрмийн 1.6-д дурдсан тэмдгээр байгууллагын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.
- 1.8. Засгийн газрын шийдвэрээр төвийг өөрчлөн байгуулах буюу татан буулгана.

## ХОЁР ТӨВИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЗАРЧИМ

### **2.1. Төвийн зорилго**

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын амбулаторын үзлэгийн цаг товлох үйлчилгээг зохицуулах замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

### **2.2. Төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг**

Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас доор дурдсан чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд нь мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэг хүлээнэ. Үүнд:

2.2.1. Эрүүл мэндийн бодлого, тогтолцооны судалгаа, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогод дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ, эрүүл мэндийн үндэсний тооцоо, эдийн засгийн дүн шинжилгээ хийх;

2.2.2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн дэвшилийг нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах;

2.2.3. Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх;

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх замаар тусламж үйлчилгээний чанарыг баталгаажуулах;

2.2.5. Донорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулж, бодлого, арга зүйгээр хангах, хяналт тавих, үр дүнг тооцох;

2.2.6. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвийн амбулаторийн үзлэгийн цаг товлох үйлчилгээний үйл ажиллагааны уялдааг зохицуулах, хангах;

2.2.7. Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;

2.2.8. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ егех;

### **2.3. Төвийн үйл ажиллагааны зарчим:**

2.3.1. Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;

2.3.2. Үйлчлүүлэгчийг дээдэлж, үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;

2.3.3. Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцыг чанд сахих;

2.3.4. Ил тод, нээлттэй ажиллаж, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах;

2.3.5. Төрийн албан хаагчийн ёс зүй, хуулийг мөрдлөг болгох.

## ГУРАВ. ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

### **3.1. Төв нь дараах эрхтэй:**

3.1.1. Өөрийн үндсэн үйл ажиллагааг хангахад чиглэсэн эрх зүйн баримт бичиг боловсруулан мөрдүүлэх;

3.1.2. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудаас эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, судалгааг гаргуулан авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх;

3.1.3. Төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд салбарын бодлого, стратеги, хууль, дүрэм, журам, стандарт, тушаал, бусад шийдвэртэй холбоотой асуудлаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагаар шийдвэрлүүлэх;

3.1.4. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг боловсруулах, батлагдсан төсвийг зөвшөөрөгдсөн бүтэц, орон тоо, байгаа нөөц, материаллаг баазад тулгуурлан хууль, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.5. Төв нь үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээний шийдвэр гаргахад зөвлөх үүрэг бүхий Удирдлагын зөвлөлтэй байх;

3.1.6. Ижил чиг үүрэг бүхий гадаадын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.1.7. Өөрийн үндсэн чиг үүргийн хүрээний асуудлаар үндэсний, бүсийн болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарыг бие даан болон хамтран зохион байгуулах;

3.1.8. Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд өөрийн үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээ, хэлцэл байгуулан ажиллах;

3.1.9. Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу холбогдох судалгаа, сургалт болон бусад үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.10. Өөрийн үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд гэрчилгээ, үнэмлэх, бэлгэдлийн загвар, бүртгэл, судалгааны маягтыг батлан гаргаж мөрдүүлэх;

3.1.11. Төв нь өөрийн байгууллагын шагнал, өргөмжлөл, тэмдэгтэй байна. Шагнал, урамшуулал олгох журмыг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн захирлын шийдвэрээр баталгаажуулах;

3.1.12. Байгууллагын ажилтныг шагналд тодорхойлох, холбогдох дээд шатны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.1.13. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн мэдээ мэдээллийг түгээх зорилгоор цахим хуудас, мэдээний сан зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээтэй байх;

3.1.14. Үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд ном, гарын авлага, эмхтгэл зэргийг гаргах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөх;

3.1.15. Төв нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд ажилтнуудын нийгмийн хамгаалал, эрх ашгийг хамгаалах, тэдний сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Хамт олны зөвлөл" болон "Эцэг эхийн зөвлөл"-тэй байх;

3.1.16. Хамт олны зөвлөлийн бүрэлдэхүүнийг төвийн нийт ажилтны хурлаар хэлэлцэж сонгох бөгөөд хамт олны зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн сонгох;

3.1.17. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

### **3.2. Төв нь дараах үүрэгтэй:**

3.2.1. Төв нь салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан байгууллагын хөгжлийн дунд хугацааны төлөвлөлтийг хийж, баталгаажуулан хэрэгжүүлэх;

3.2.2. Төвийн зорилго, үндсэн чиг үүргийн хүрээнд хууль, тогтоомж, сайдын тушаалыг хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн бусад байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Төвийн чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуурыг ханган ажиллах;

3.2.5. Байгууллага, иргэд, үйлчлүүлэгчдийг өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.6. Байгууллага, иргэд, үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, дүн шинжилгээ хийж, запруулах, эргэн мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.7. Нягтлан бодох бүртгэл, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж төсөв, санхүүжилтийн үр дүн, үр ашгийг тооцож, тайлагнах;

3.2.8. Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.9. Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй ажиллах;

3.2.10. Ажилтны нийгмийн баталгааг хангах, ажиллах дэмжлэгт орчин бүрдүүлэх талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.11. Ажилтны мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах, сахилга, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

3.2.12. Бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасан үүрэг.

## **ДӨРӨВ. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 4.1. Төвийн удирдлага нь Захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.2. Төвийн Захирал нь байгууллагын үндсэн чиг үүрэг, хөгжлийн төлөвлөгөө, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, энэхүү дүрэмд заасан төвийн эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
- 4.3. Удирдлагын зөвлөл нь захирлын шийдвэр гаргах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зөвлөх, дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.4. Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийг алба гэж нэрлэх бөгөөд нэгжийг албаны дарга удирдана.
- 4.5. Төвийн Удирдлагын зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг төвийн захирал батална. Удирдлагын зөвлөлийг төвийн захирал удирдана.
- 4.6. Төвийн захирал тушаал, Удирдлагын зөвлөл хурлын шийдвэр тус тус гаргана.

### **4.7. Төвийн захирлын эрх, үүрэг:**

- 4.7.1. Төвийн бүтэц, үндсэн чиг үүрэг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг, байгууллагын дотоод журам, хөгжлийн хөтөлбөр, байгууллагын стратеги төлөвлөгөө, ойрын болон хэтийн хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой журмуудыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.7.2. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан нэгж, түүний орон тоо, ажилчдын цалин хөлсийг тогтоох;
- 4.7.3. Ажилтны албан тушаалын тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд авах, хууль тогтоомжийн хурээнд ажлаас чөлөөлөх, халах, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, цуцлах;
- 4.7.4. Ажилтныг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах, захиргааны чөлөө олгох;
- 4.7.5. Ажлын үр дүнг үндэслэн ажилтныг шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх;
- 4.7.6. Хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах;

- 4.7.7. Төвийг гадаад, дотоодод бүрэн хэмжээгээр төлөөлөх;
- 4.7.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид ажиллах;
- 4.7.9. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, биелэлтийг ханган ажиллах;
- 4.7.10. Ажилтны талаар гаргасан өргөдөл, гомдлыг дангаараа буюу холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэх;
- 4.7.11. Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- 4.7.12. Байгууллагын үндсэн чиг үүрэг, бутцийн нэгжийн чиг үүргийн онцлогт нийцүүлэн ажлын байр, албан тушаалын чиг үүргийг нэгжийн удирдлага боловсруулж, захирал баталгаажуулна;
- 4.7.13. Хуулиар олгогдсон бусад эрх, үүрэг.

#### **ТАВ. ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ**

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1. Улсын төсөв
- 5.2. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого
- 5.3. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- 5.4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

#### **ЗУРГАА. ТӨВИЙН ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- 6.1. Төв нь эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, яам, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.
- 6.2. Төв нь өөрийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд бусад байгууллага, иргэдтэй шууд харилцана.
- 6.3. Гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, зочид, төлөөлөгч урих, үндсэн чиг үүргийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр гадаад харилцаагаа хөгжүүлэн ажиллана.
- 6.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээнд байгууллагаа төлөөлж, гарын үсэг зурах эрхийг төвийн захирал эдэлнэ.
- 6.5. Төвийн захирлын гадаад, дотоод томилолтыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, төвийн бусад ажилтнуудын гадаад, дотоод томилолтын асуудлыг төвийн захирлын шийдвэрээр баталгаажуулна.

## ДОЛОО. ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ТОГТОЛЦООНЫ ЕРӨНХИЙ ЗАГВАР, НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, бүтцийн тогтолцооны ерөнхий загварыг үндэслэн тус төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна.

### **7.1. Эрүүл мэндийн эдийн засаг, судалгаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.1-ийн хүрээнд:

7.1.1. Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлаар бодлого, тогтолцооны судалгаа хийх, мэдээний нэгдсэн сан бүрдүүлэх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах;

7.1.2. Эрүүл мэндийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах;

7.1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлогод дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, хүний нөөц, эрэлт хэрэгцээнд судалгаа, дүн шинжилгээ хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоо мэдээллээр хангах;

7.1.4. Нийтмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлогод дэмжлэг үзүүлэх, бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах;

7.1.5. Эрүүл мэндийн байгууллагын эдийн засаг, санхүүжилтийн дүн шинжилгээ хийх, эдийн засгийн үр ашиг, үр дүн, өргтийн тооцоо судалгаа хийх, тайлагнах;

7.1.6. Олон улсын стандартад нийцүүлэн Эрүүл мэндийн үндэсний тооцооллын тогтолцоог хөгжүүлэх, тайлагнах, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах;

7.1.7. Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй технологид судалгаа, дүн шинжилгээ хийх, нэгдсэн мэдээний сан бүрдүүлэх;

7.1.8. Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Нэгжийн үйл ажиллагаа нь салбарын тулгамдсан асуудлаар бодлого болон эдийн засаг, санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, дүн шинжилгээг салбарын тэргүүлэх чиглэл, хүн амын өвчлөл эндэгдэл, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamжийн хэрэгцээ, түүний гүйцэтгэлтэй уялдуулан хийж, дээрх асуудлуудаар шийдвэр гаргахад хэрэглэгчдийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангаж салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөвлөлт, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага /Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга/, төвийн захирал байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бусад нэгж, нутгийн захиргааны төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, төв орон нутгийн статистик мэдээллийн байгууллагууд, судалгааны байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд байна.

## **7.2. Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.2-ын хүрээнд:

7.2.1. Эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, тайлагнах, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

7.2.2. Өвчний олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хэрэглээг сайжруулах ажлыг зохион байгуулах;

7.2.3. Үндэсний эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, төслийн мэдээг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.2.4. Хүн амын өвчлөл, төрөлт, нас бааралтын мэдээллийн баазад тулгуурлан тархвар зүйн дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

7.2.5. Хүн амын эрүүл мэндийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, програм хангамж, нэгдсэн сүлжээний тогтвортой үйл ажиллагаа, аюулгүй байдал, нууцлалыг хангах;

7.2.6. Эрүүл мэндийн салбарын нэгдсэн цахим мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг зохион байгуулах, сургалт, мэргэжил, арга зүйгээр хангах;

- 7.2.7. Эрүүл мэндийн мэдээлэл, мэдээллийн технологийн мэргэжилтнийг мэргэжлийн удирдлагаар хангах, чадавхжуулах;
- 7.2.8. Байгууллагын мэдээллийн технологи, үйл ажиллагааны найдвартай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;
- 7.2.9. Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээлэлд чанарын хяналт үнэлгээг хийж, мэдээллийн үнэн бодит байдлыг хангах;
- 7.2.10. Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Нэгжийн үйл ажиллагаа нь салбарын статистик мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ, чанарын хяналт хийх, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, үнэн бодит байдлыг дээшлүүлэх, шаардлагатай мэдээллийн технологийг хөгжүүлэх, цахим эрүүл мэнд, зайн оношилгоо, эмчилгээний нэгдсэн сүлжээний тогтвортой, найдвартай байдлыг хангах, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангаж салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого төлөвлөлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага /Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга/, төвийн захирал байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бусад нэгж, нутгийн захиргааны төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, төв орон нутгийн статистик мэдээллийн байгууллага, судалгааны байгууллага, олон улсын байгууллага, эрүүл мэндийн байгууллагууд байна.

### **7.3. Хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.3-ын хурээнд:

7.3.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээнд үнэлгээ хийх, ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

7.3.2. Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээг судлах, сургалтын хөтөлбөр, мэргэшүүлэх сургалтын чиглэл, индекс батлуулах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, арга зүй, зохицуулалтаар хангах, дэмжлэгт орчныг бүрдүүлэх;

7.3.3. Төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллагуудын сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинд үнэлгээ хийх, чадавхийг бэхжүүлэх, сургагч багш нарын сурган заах арга зүйг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;

7.3.4. Эрүүл мэндийн ажилтныг гадаад улс оронд суралцуулах, эрэлт хэрэгцээг судлах нэгдсэн төлөвлөлт хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

- 7.3.5. Эрүүл мэндийн удирдах ажилтныг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- 7.3.6. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг үнэлэх, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 7.3.7. Салбарын хүний нөөцийн мэдээний нэгдсэн санг бүрдүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах, баяжилт хийх, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах;
- 7.3.8. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, шалгалт авах, сорилын санг баяжуулах, үнэлэх, нууцлал, аюулгүй байдал, мэргэжил арга зүй, мэдээллээр хангах, зохион байгуулах;
- 7.3.9. Эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн судалгаа, төлөвлөлтийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх, мэргшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд элсүүлэх хяналтын тоог тогтоох, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцөөр хангах, төгсөгчдийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- 7.3.10. Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачааллын судалгаа хийх, норм нормативыг тогтоох санал боловсруулах;
- 7.3.11. Сувилагч, тусгай мэргэжилтний тоог нэмэгдүүлэх эмч, сувилагчийн харьцааг зохистой түвшинд хүргэх, мэргэжлийн чиглэл индексийг баяжуулах, мэргшүүлэх дэмжлэгт орчныг бүрдүүлэх;
- 7.3.12. Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн болон хувь мэргэжилтний лавлагааны сан бүрдүүлэх, баяжилт хийх, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 7.3.13. Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, нийгмийн баталгааг сайжруулахад төрийн захиргааны төв байгууллагад туслалцаа дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сургалт зохион байгуулах байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт-үнэлгээ хийх, өндөр хөгжилтэй оронд мэргэжилтэн бэлтгэх, удирдах ажилтныг сургах, мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохих мэдээний санг бүрдүүлж, нууцлал аюулгүй байдлыг хангах, баяжилт хийх, шийдвэр гаргагч, эрүүл мэндийн байгууллага, ажилтан, иргэдийг мэдээллээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээр үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага /Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга/, төвийн захирал байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамны зохион байгуулалтын бусад нэгж, эмнэлгийн байгууллагууд, эрүүл мэндийн ажилтнууд, олон улсын байгууллагууд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь эрүүл мэндийн сургалт эрхлэгч байгууллагууд, анагаах ухааны их, дээд сургуулиуд, олон улсын байгууллагууд байна.

#### **7.4. Магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.4-ийн хүрээнд:

7.4.1. Эрүүл мэндийн салбарын Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн ажлын албаны үүрэг гүйцэтгэж, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоодтой хамтран ажиллах, арга зүйгээр хангах;

7.4.2. Орон тооны бус шинжээчдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, шинжээчдийн багийг арга зүйгээр хангах, хяналт тавих, гүйцэтгэлийг үнэлэх, чадавхижуулах;

7.4.3. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй тусlamж үйлчилгээний технологи, чанар, гүйцэтгэлд батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах;

7.4.4. Магадлан итгэмжлэлийн зарим үйл ажиллагааг хуулийн этгээд, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоод, эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, гэрээ байгуулах, дүгнэх;

7.4.5. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэдээний сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;

7.4.6. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний эрсдэл, аюулгүй байдал (алдаа, зөрчлийн бүртгэл)-ын мэдээний санг бүрдүүлэх, үнэлгээ хийх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, хүлээгдлийн судалгаа, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.4.7. Олон улсын эмнэл зүйн удирдамж, заавар, стандарт, чанарын баталгаажилтын үйл ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ хийх, тусlamж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах;

7.4.8. Эрүүл мэндийн газар, байгууллагын эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд үнэлгээ хийх, хянах, зөвлөмж өгөх, биөлэлтийг хангуулах;

7.4.9. Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэхүү нэгжийн үйл ажиллагаа нь магадлан итгэмжлэлийн зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж, хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, тусlamж үйлчилгээний алдаанаас сэргийлэх, аюулгүй байдал, эрсдэлийн

удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагуудын чанарын албыг мэргэжил арга зүйгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн захиргааны удирдлагын газар болон Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар болон бусад холбогдох бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага /Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга/, төвийн захирал байна.

Энэ үйлчилгээний шууд бус хэрэглэгч нь яамны бусад зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн ажилтан, иргэд, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвш нь эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн хяналтын бүх шатны байгууллага, олон улсын байгууллага, яамны мэргэжлийн салбар зөвлөлүүд байна.

#### **7.5. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.5-ын хүрээнд:

7.5.1. Донорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулах, эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлага, арга зүй, нэгдсэн зохицуулалтаар хангах, хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах;

7.5.2. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний заавар удирдамжийг багуутдтай хамтран шинэчлэн боловсруулж, батлуулах;

7.5.3. Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, тархины үхэлтэй донор илрүүлэх, эрхтэн хамгаалах эмчилгээг эрчимт эмчилгээний тасагт хийх үйл ажиллагааг нэгдсэн чиг удирдлагаар хангах, өргөжүүлэх;

7.5.4. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн буртгэл мэдээний сан бүрдүүлэх, эд, эрхтэн хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах;

7.5.5. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд оролцож буй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, цалин хөлс нийгмийн баталгааг сайжруулах;

7.5.6. Донорын үйл ажиллагааг сурталчилах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, анагаах ухааны шинэ технологийг эмчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах /эс, эдийн болон хүйн цусны банк байгуулах үйл ажиллагааг зохицуулах/;

7.5.7. Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийх эрх бүхий эмнэлэг, түүний удирдлага бөгөөд тухайн эмнэлэгт эмчлүүлэн хяналтанд байж эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд орох шаардлагатай эмчлүүлэгч тэдгээрийг эмчилж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн байна. Түүнчлэн Донор эмнэлэг буюу Боломжит донор эмчлүүлж буй эмнэлэг түүний удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд байна. Энэхүү өргөн цар хүрээтэй ажлыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Эмнэлгийн тусламжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүгээр дамжуулан яамны удирдлага /Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга/, төвийн захирал бодлогоор дэмжин хяналт тавин үр дүнг тооцон ажиллана.

Энэ эмчилгээг өргөжүүлэн хөгжүүлж эрдэнэт хүний амь насыг аюулт өвчнөөс аврах үйл хэрэгт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах гол хүч нь өргөн олон түмэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэндийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын ижил төстэй үүрэг бүхий байгууллага, хууль, мэргэжлийн хяналт, эмнэлэүйн сургалтын байгууллага байна.

#### **7.6. Дуудлагын цаг зохицуулах үйлчилгээг хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт:**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.6-ын хүрээнд:

7.6.1. Эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэгийн цаг товлох үйл ажиллагааг зохион байгуулах, хоорондын уялдааг зохицуулах, үйлчилгээг өргөжүүлэх, зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагын ажилтныг татан оролцуулах, хамтран ажиллах, удирдан чиглүүлэх, дуудлага зохицуулах ажилтныг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах, чадавхижуулах;

7.6.2. Үзлэгийн цаг товлох үйлчилгээг сурталчиллах, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах;

7.6.3. Цаг товлох үйл ажиллагааны чиглэлээр мэдээллийн сан бурдүүлэх, судалгаа хийх, хяналт тавих, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

7.6.4. Цаг товлох үйлчилгээний програм хангамж, сүлжээний аюулгүй байдал, тогтвортой үйл ажиллагааг хангах;

7.6.5. Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвийн амбулаторийн үзлэгийн ачааллыг зохицуулахад дэмжлэг үзүүлэх, цаг товлох үйлчилгээний улмаас эмнэлэгт хандах иргэдийн хэт төвлөрлийг бий болгохгүй

байх, чирэгдлийг бууруулах, мөн үзлэгийн кабинет, нэгжийн хүлээгдлийн мэдээг нэгтгэн, судалж шийдвэр гаргах түвшиний удирдлагыг мэдээллээр ханган улмаар тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж, аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бусийн оношилгоо эмчилгээний төв, эрүүл мэндийн төв, тусгай мэргэжлийн төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд, бусад хэрэглэгч байна.

#### **7.7. Захиргаа, санхүү, удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.7-ын хүрээнд:

7.7.1. Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, нэгжүүдийн уялдаа, нэгдсэн зохицуулалтыг хангаж, удирдлагыг шийдвэр гаргахад хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх;

7.7.2. Хүний нөөцийн хөгжил, төлөвлөлт, хангалтыг оновчтой зохион байгуулж, цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах;

7.7.3. Сахилга, дэг журам, ёс зүйн хэм хэмжээ, ажлын цаг ашиглалтыг сайжруулахад дэмжлэгт удирдлагаар хангах;

7.7.4. Байгууллагын төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийг оновчтой, зарцуулах, тайлагнах, санхүү, нягтлан бodoх бүртгэл тооцоог холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулах, холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх, тайлагнах;

7.7.5. Төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангаж "Шилэн дансны тухай" хуулийн хүрээнд санхүүгийн мэдээллийг ил тод нээлттэй байх үйл ажиллагааг зохион байгуулах;

7.7.6. Төвийн өмч, үндсэн хөрөнгийг олгогдсон эрх хэмжээний хүрээнд оновчтой захиран зарцуулах, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;

7.7.7. Салбар болон салбар дундын уялдаа холбоог нягtruулж, олон нийт, гадаад харилцааны хамтын ажиллагаа, маркетингийг өргөжуулэх, байгууллагын үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн оролцоог дэмжих, үйл ажиллагааны ил тод байдлыг бүрдүүлэх;

7.7.8. Архив, албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, түүхт арга хэмжээг баримтжуулах, номын сангаар үйлчлэх;

7.7.9.Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтад суралцах хугацаанд байраар хангах ажлыг зохион байгуулах;

7.7.10.Байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулах болон ажлын байрны орчин нэхцлийг сайжруулах, дэмжлэгт орчинг бурдүүлэх;

7.7.11.Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажил, үүргээ гүйцэтгэх боломжийг хангах, хүний нөөцийг хөгжүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, ажилчдын нийгмийн баталгааг хууль тогтоомж, бодлогын хүрээнд хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь төвийн захирал, бүтцийн нэгжүүд, нийт ажилтан байна. Энэ үйлчилгээг шууд бус хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын асуудал болон төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвш нь Сангийн яам, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийн холбогдох нэгжүүд, эмнэлгийн байгууллагууд, олон улсын байгууллагууд байна.

#### **7.8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт**

Энэ нэгж нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн 2.2.8-ын хүрээнд:

7.8.1.Нэгжийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнд дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээг бие даасан, хараат бусаар хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

7.8.2.Төвийн үйл ажиллагааны чанар, үр дунг үнэлэх, нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих;

7.8.3.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

7.8.4.Ажилтан, албан хаагчдын сахилга, дэг журам, ёс зүйн хэм хэмжээ, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих;

7.8.5.Чиг үүрэгтэй холбогдох бусад ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, төвийн чиг үүрэгтэй холбогдон гарсан шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хууль тогтоомж, тушаал, шийдвэр, бодлого,

хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах; төвийн хариуцсан ажлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах; эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг хэрэгжүүлж, төвийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь төвийн захирал, бүтцийн нэгжүүд, нийт ажилтан байна. Энэ үйлчилгээг шууд бус хэрэглэгч нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвш нь ЭМЯ-ны зохион байгуулалтын бүтцийн холбогдох нэгжүүд, эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд байна.

#### **НАЙМ. БУСАД**

8.1. Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох эрх зүйн бичиг баримтаар зохицуулна.

--oo0oo--

Эрүүл мэндийн сайдын  
2021 оны 10 сарын 20-ны өдрийн тушаалын  
хоёрдугаар хавсралт



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН БҮТЭЦ

